



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2016 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 34

Мандалговь

┌ Хөрөнгө худалдах тухай ┐

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.3 заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 5.8.а дахь заалтуудыг тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Луус сумын Цэцэрлэгийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 85,659,500 /наян таван сая зургаан зуун тавин есөн мянга таван зуу/ төгрөгийн анхны өртөгтэй, 57,306,205 /тавин долоон сая гурван зуун зургаан мянга хоёр зуун тав/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй цэцэрлэгийн барилгыг, барилгын доорх газрын хамт актлан худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгө худалдах үнийн доод хязгаарыг 25'000'000 /хорин таван сая/ төгрөгөөр тогтоон нийтийн дуудлага худалдааг журмын дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газрын дарга С.Ууганбаярт үүрэг болгосугай.

3. Худалдсан эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу данс бүртгэлээс хасахыг Луус сумын Цэцэрлэгийн эрхлэгч Л.Цогзолмаад даалгасугай.

ДАРГА

С.СҮХБААТАР

